

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА
НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ

2022 01 03

7/09

Ажилд томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дүгээр зүйлийн 56.6, Авлигатай тэмцэх газрын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05/13447 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Багийн Иргэдийн нийтийн Хуралд оролцсон иргэдийн, түүнчлэн төлөөлөгчдийн олонхийн санал авсан 1 дүгээр багийн Засаг даргаар П.Амгаланбаатарыг, 2 дугаар багийн Засаг дарга Г.Сосорбурамыг, 3 дугаар багийн Засаг дарга Б.Баатарсүрэн нарыг 2022 оны 01 дугаар сарын 03-ний өдрөөс Багийн засаг даргаар томилсугай.

Хоёр. Багийн Засаг дарга нарын сарын үндсэн цалинг 697388 (Зургаан зуун ерэн долоон мянга гурван зуун наян найман) төгрөгөөр тогтоож, онцгой нөхцлийн 30 хувийн нэмэгдлийг журмын дагуу сар бүр тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Үүрийнтуяа)-д үүрэг болгосугай.

Гурав. Албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын чиг үүрэг, багийн иргэдийнхээ хүн амын амжиргааны түвшинг судлах, мал, хүн ам, иргэний бүртгэл, статистик мэдээллийг үнэн зөв гаргаж мэдээлэх, олон нийтийн ажилд иргэдийг татан оролцуулах, идэвхижүүлэх болон сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний үүргийг биелүүлэн, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, хөрөнгө орлогын мэдүүлгийг 30 хоногийн хуулийн хугацаанд мэдүүлж, хуулиар олгосон бусад чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Багийн Засаг дарга (П.Амгаланбаатар), (Г.Сосорбурам), (Б.Баатарсүрэн) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАЯРСҮХ

488020041